



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/34

Мандалговь

Өсвөрийн шатарчдын  
улсын аварга шалгаруулах тэмцээнд  
зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотод 2021 оны 12 дугаар сарын 18-22-ны өдрүүдэд зохиогдох өсвөрийн шатарчдын улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдын бэлтгэл сургуулалтыг ханган оролцуулахыг дасгалжуулагч (М.Билгүүн)-д үүрэг болгосугай.

2. Өсвөрийн шатарчдын улсын аварга шалгаруулах тэмцээний төсвийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Тэмцээний зардалд шаардагдах 1.010.000 (Нэг сая арван мянга) төгрөгийг тэмцээн уралдааны зардлаас гаргахыг ерөнхий нягтлан бодогч (Б.Мөнхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ А.ОТГОНБААТАР

